

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

АЯрилцлага өгөгчийн нэр	Аюурын Цэрэндорж	Дугаар	L131
Оршин суугаа аймаг	Сүхбаатар	Оршин суугаа сум	Наран
Төрсөн газар		Төрсөн он	1923
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Молцогийн хийд	Сүм хийдийн дугаар	СБНР 009
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 28	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Сүхбаатар аймгийн Наран сумын Молцогийн хийд

-Танай сумд ямар ямар хийд байсан бэ? Эрдэнэ Өлзийтийн хийд гэж дуулсан уу та?

Эрдэнэ Өлзийтийн хийд гэж байсан. Баруунтаа. Сайн худаг гэдгээс наашаа. Гүн худгийн тэнд хийд байсан туурь байгаа. Лам нарын сууж байсан ханзтай гэрийн бүүр байсан. Намайг бага байхад байхгүй болсон хийд юм.

-Та өөрөө хаагуур нутаглаж байсан бэ?

Би уг нь Онгон сумын хүн.

-Онгон сумын хийдүүдүүдийг хэр мэдэх вэ?

Хансын сүм, баруунтшаа Бударын чулуун дотор хийд байсан.

- Эх булгийн хийд гэж байсан уу?

Байсан.

Дэрсэн сүм гэж байсан уу?

Тэрийг чинь Хансын сүм гэдэг байсан юм.

-Цагаан худгийн хийд гэж байсан байна?

Тэр чинь бүр баруун хойшоо байсан.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувиин мэдээллээс бүрдсэн болно.  
© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Мөн Их булгийн хийд?

Тийм.

Бор хошуу гэдэг газар Худгийн хийд гэж байж?

Тэр мэдэхгүй юм аа.

-Өөр таны дуулснаар ямар хийдүүд байсан бэ?

Цагаан худгийн сүм гэж баруун хойшоо байсан.

-Та энэ Молцогийн хийдийн тухай мэдэх үү? Хэдэн ламтай байсан, хэдэн дугантай байсан гээд?

Сайн мэдэхгүй дээ. Жаахан байсан болохоор.

-Молцогийн хийдэд цам гардаг байсан гэсэн?

Тийм гэсэн.

-Та цамыг нь үзэж байсан үү?

Үгүй ээ. Бага байсан болохоор үзэж байгаагүй. Онгонд чинь хойшоогоо Байшинтын хийд гэж байсан.

Баяндэлгэрийн үү?

Баяндэлгэрээс нааш. Тэр Онгоны элсний чинь ард. Байшинтын дивиз гэж байсан.Тэнд чинь харин цам гарч байсан юм.

Тэрийг харин би мэднэ. Тэнд ээжтэйгээ очиж цам хурж байхыг харж байсан.

-Та Наран, Онгон сумынхаа аль хийдийн талаар сайн мэдэх вэ?

Би Молцогийн хийд дээр нэг л очиж байсан.

-Тэр хэдэн дугантай байсан бол доо?

Ёстой мэдэхгүй.Би чинь одоо жаахан байсан болохоор их анзаараагүй. Лав л нэг хурал хурдаг дөрвөлжин байшин байсныг санаж байна. Тэрний ард нь их бурхантай шүтээн гээд байсан. Өөр одоо юу байсныг нь мэдэхгүй юм. Онгон сумд Дөрвөн худгийн сүм гэж байсан. Цөөн ламтай 1 дугантай, ард нь шүтээн гээд жижигхэн өндөр байшинтай, хэдэн өвгөн лам нар суудаг байсан. Тэгэхэд би хонь хариулаад нэг их бороо орох гээд хийдэд ойрхон явж байсан тэнд очсон. Жаахан гэлэн гээд өвгөн лам байх. Тэр л бороог хорих гэж байгаа юм уу, зүүн хойно нь аргалын хашаа гээд том хашаа байсан тэрний тэнд оччихсон ном уншаад байсан. Тэгтэл ч бороо орлоо доо. Цутгачихлаа. Манай хонь ч яахав байшин гэрийн нөмөрт зогсчлоо. Нэлээн удаан тэгж орлоо. Хойд талын шүтээний байшин чинь шавар ч байсан юм уу, халтартаад л урсаад л байсан. Тэгээд тэрнээс хойш л удаагүй л байхгүй болсон л доо.

-Дөрвөн худгийн хийд хэр олон дугантай, хэдэн ламтай байсан бэ?

10-аад лам байсан байх.

-Цагийн хурал байсан уу, өдөр тутам байнга хурдаг байсан үү?

Хаа нэг хурдаг хурал байсан байх.

-Хийдийг удирдаж байсан хүн нь жаахан гэлэн гэдэг хүн үү?

Одоо мэдэхгүй. Тэр байсан уу, өөр хүн байсан уу. Жаахан гэлэн л байнга байдаг лам байсан.

-Өөр танд энэ Нарангийн хийдүүдээс мэдэх зүйл юу байна? Сонссон дуулсан?

Мэдэхгүй юм даа.

Талын Модонгийн хийд гэж байсан юм гэсэн.